

Ч.ДАЛАЙ МОНГОЛЫН БӨӨ СУДЛАЛД

С. Өлзийбаяр*
Ю.Болдбаатар**

Шарын шашны бүрдлүүдтэй ихээхэн холилдож унаган шинжээ ихэд гээсэн ч ард олны дунд тодорхой нэр хүндтэй байсан бөөгийн соёл, зан үйлийг хадгалан үлдээхэд чиглэгдсэн судалгаа хийх зайлшгүй шаардлага шашингүй үзлийг хурц зэвсэг болгосон цагийн төр, засгийн бодлогоос урган гарчээ. Тиймээс ч бөөгийн талаарх судалгааг тухайн цаг үеийнхээ нөхцөл байдлыг зөв ухамсарласан “дэвшилтэд” зарим цөөн судлаачид 1950-иад оноос идэвхийлэн хийх болжээ. Тухайлбал, Б.Ринчен бөөгийн соёл, зан заншилтай холбоотой мэдээ сэлт цуглуулан заримаас нийтлүүлж байсан бол Ц.Дамдинсүрэн бөөгийн дуудлага нь монголын уламжлалт яруу найргийн чухал хэлбэр болохыг нотлон харуулахыг оролдож, Х.Пэрлээ музейн сан хөмрөгт хадгалагдаж асан бөөгийн эдлэл хэрэгсэлийг тайлбарлах зэрэг ажлуудыг хийж байжээ. Эдгээрээс Ч.Далай монголын бөөгийн шүтлэг, зан үйлийн өөрчлөлт хөгжилтийг анх удаа түүхчлэн үзэж, түүний мандан буурсан бодит шалтгаан, ертөнцийг үзэх үзэл, бөөгийн зарим эдлэл хэрэгсэл, зан үйлийн нарийн утга санааг тайлах оролдлого хийж уламжлалт шүтлэг бөө нь цар хүрээгээрээ шашны хэмжээнд хараахан хүрээгүй учраас бөөгийн мөргөл хэмээх дүгнэлтэнд хүрсэн нэг сэдэвт зохиолоо хэвлүүлсэн нь ихээхэн содон үйл явдал болсон юм.

1950-иад оноос ЗХУ, БНХАУ болон дотоодод түүхийн дээд боловсрол эзэмшсэн судлаачид олноор төрөн гарсан нь монголын түүхийн судалгаа эртний судлал, угсаатан судлал, түүх бичлэг зэрэг түүхийн салбар чиглэлээр гүнзгийрэх таатай боломж бүрдсэн юм. Ялангуяа, эртнээс өргөн харилцаат өмнөд хөрштэйгээ соёл, шинжлэх ухааны салбарт нягт хамтран ажиллах нь монголын түүх судлалын хөгжилд үлэмж ач холбогдолтой учраас хоёр талаас энэ талаар ихээхэн анхаарал хандуулж байлаа. Тухайлбал, 1958 онд БНХАУ-ын төлөөлөгч Ся Янь, Чжан Чжи-сян нар БНМАУ-ын Соёлын яамны сайдтай хийсэн уулзалтын үеэр Монголын түүхийг хамтран бичих тухай, Хятадад байгаа материалаар туслах тухай яригдсан нь¹ тэдний зүгээс манай улсын түүхийг бичилцэх сонирхолтой байсны илрэл төдийгүй нөгөө талаар үндэсний түүхийн шинжлэх ухааны гадаад дахь нэр хүнд ихэд бэхжсэнийг харуулсан хэрэг юм.

Харин манай улсын зүгээс БНХАУ-д дээд боловсролтой боловсон хүчин бэлдэхэд асар их анхаарч цөөнгүй залуусыг тэнд сургасны нэг нь Ч.Далай байсан юм. Тэрээр 1956 оноос эхлэн холбогдох хэрэглэгдэхүүн цуглуулахаар баруун аймгуудын нутгаар явсан төдийгүй Өвөр Монголын зарим нутаг дахь бөөгийн холбогдолтой хэрэглэгдэхүүнээс нэлээдгүй цуглуулан хятад, манж, монгол сурвалж дахь мэдээ баримттай харьцуулан хоёр жилийн дараа Бээжингийн ИС-ийг түүхч мэргэжлээр төгсөхдөө тус

* С.Өлзийбаяр - ШУА-ийн Түүхийн хүрээлэн, доктор (Ph.D)

** Ю.Болдбаатар - ШУТИС-ийн НТС, доктор (Ph.D)

сэдвээр диплом хамгаалах ажил бичжээ. Түүний эрдмийн ажлын удирдагч Бээжингийн их сургуулийн багш профессор Шао Шэнь-жэн болон бусад багш нар тус зохиолыг бичихэд ихээхэн үнэтэй сургамж өгсөн талаар зохиогч нэн сэтгэл ханамжтай дурдсан байдаг бөгөөд 1959 онд олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар хурлын өмнө түүний эл зохиолыг “Монголын бөөгийн мөргөлийн товч түүх” нэртэйгээр хэвлүүлжээ.

Бөө мөргөл нь Төв Азийн нүүдэлч ард түмний төдийгүй зарим суурьшмал соёлт иргэдийн оюуны амьдралын олон мянган жилийн түүхийг хүүрнэгч чухал хэрэглэгдэхүүн учраас зөвхөн монгол хэлт нүүдэлчдийн хүрээгээр хязгаарлалгүй манж, хятад, солон үндэстний уламжлалт шүтлэгийн соёл, зан үйлийн судалгааны бүтээлүүдийг хамруулсан нь зохиолын шинжлэх ухааны ач холбогдолыг үлэмж өргөжээ. Монголчуудын оюуны амьдралд бөө мөргөл нь эртний улсуудын, Их Монгол улсын үеийн ба өдгөө цагийн монголчуудын гэж үечлэн үзэх боломжтой онцлог үе шатуудыг туулан ирсэн гэж үзсэн байна. Энэхүү үечлэлийг хожмын бөө судлаачид зарчмын хувьд хүлээн зөвшөөрсөн нь түүний эл зохиол орчин цагийн бөөгийн түүх судлалын үндэс болсон гэж дүгнэхэд хүргэж байна. Тухайлбал, Өвөр Монголын судлаач Х.Буянбат, Д.Мансан, Ёнсог нарын бүтээлд бөөгийн түүхийг эл зарчмаар үечилсэн байна.² О.Пүрэвийн бөө судлалын нэг сэдэвт зохиол “Монгол бөөгийн шашин” номны бүтэц нь үндсэндээ Ч.Далайн зохиолынхтой тун төслөг байна.

Шашны онолын хүрээнд Ч.Далай анх удаа бөөгийн шүтлэгийг “бөөгийн мөргөл” хэмээн үзэх нь зүйтэй гэж томъёолсон нь хожмын судлаачдын анхаарлыг энэ асуудалд хандуулахад хүргэж, шашин эсвэл түүний өмнөх шүтлэгийн нэгэн хэлбэрийн чухам аль хүрээнд нь хамаатуулах талаар эдүгээ нэгдмэл үзэл баримтлал төлөвшөөгүй байна. Түүний бөөгийн шүтлэгийг шашны хэмжээнд хүрээгүй гэх тайлбар нь онолын хувьд ихээхэн маргаантай учраас “... уг шүтлэгийн хэлбэрийг дэлхийн бусад шашны нэг адил үзэх нь зарим талаар дутагдалтай учир бид энэ удаад уг асуудлыг гүнзгийрүүлэн хөндөлгүй одоохондоо “бөө мөргөл” хэмээх нэрийг хэрэглэж байх нь зүйтэй мэт санагдана”³ хэмээн ахисан судалгааны түвшинд жичдээ тусгайлан авч хэлэлцэх нь зүйтэй болохыг заажээ.

Бөөгийн 99 тэнгэрийн үзлийн тухай Д.Банзаровын судалгааг монголчуудын дунд тархсан “тэнгэр” шүтлэгийн хэлбэрээр баяжуулан тус бүр 99 зүйлийн үзэгдлийг захирсан эзэн гэж дүгнэлтэнд хүрсэн нь бөөгийн зан үйлийн судалгааны арга зүйн системчлэлд чухал ач холбогдолтой зүйл болсон юм. Нөгөө талаар 1950-иад оны үеийн зарим ястны дунд хадгалагдаж асан бөөгийн зарим зан үйлийн талаар тэмдэглэн үлдээсэн нь шинжлэх ухааны үнэт хэрэглэгдэхүүн болж байна. Эдгээр цөөхөн баримт нь монголын бөөгийн зан үйл, соёлыг чухам ямар арга зүйн зарчмаар хэрхэн судлавал зохистой болохыг Ч.Далай “Монголын бөөгийн мөргөлийн түүх” зохиолоороо тавьж өгсөн гэж дүгнэхэд хүргэж байна. Өөрөөр хэлбэл, монголчуудын оюуны амьдралын түүхийн шинэ үеийн судалгааны эхлэл болсон юм.

Монголын бөө мөргөлийн түүх, соёлыг судлагч, сонирхон уншигч, оюутан залуус хэн бүхэнд “Монголын бөөгийн мөргөлийн товч түүх” зохиол гарын авлага болсоор 50 жил өнгөрчээ. 1978 онд Бээжинд хятадаар, 1990 онд Хөх хотод монголоор тус бүр дахин хэвлэгдэхийн хамт дотоод, гадаадын бөө судлалын олон түвшний судалгааны бүтээлүүдэд ишлэгдсээр байгаа нь монголын төдийгүй хятад зэрэг орны судлаачдын хэдийн танил болсон цаг хугацааны шалгуураар уг бүтээлийг эрэлт ихтэй, суурь судалгааны томоохон бүтээл болохыг нотлон харуулж буй хэрэг билээ. Ялангуяа монгол судлал өндөр хөгжсөн барууны орнууд, япон, хятад, солонгос зэрэг улсын эрдэмтдийн анхаарлыг байнга татдаг олон улсын хэмжээний түүхийн суурь судалгааны бүтээл болжээ.

Тиймээс ч зохиогч “Монголын бөөгийн мөргөлийн товч түүх” хэмээх энэхүү бэсрэг зохиолоо ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн 2006-2008 оны “Монголын түүх бичлэг, эртний түүх, сурвалж судлал” сэдэвт ажлын хүрээнд нэмэн засварлаж хэвлүүлэхээр төлөвлөсөн юм. Дахин хэвлүүлэх үндсэн шалтгаан нь

1. Эхний хэвлэл шашны хор холбогдлыг тайлбарласан шинжлэх ухааны хялбарчилсэн зохиолыг олноор нийтлэн гаргах шашингүйн үзлийн үүднээс бичигдсэн нь өдгөө цагийн уншигчдын оюуны хэрэгцээнд нэгэнт нийцэхээ больсон. Бөө шүтлэгийг цөөнхийн ноёрхолыг бэхжүүлэгч хэрэгсэл хэмээх ангич байр сууринаас бус нүүдэлчдийн оюуны үнэт өв болох талаас нь олон нийтэд харуулах шаардлага гарчээ.

2. Ном хэвлэгдснээс хойш нийгээм, улс төрийн байдал эрс өөрчлөгдөж ардчилал, үндэсний ухамсар илт сэргэж, уламжлалт бөөгийн шүтлэг өргөн түмний дунд дахин дэлгэрэх болсонтой уялдаад эл зохиолын эрэлт, хэрэгцээ практик ач холбогдол өссөн.

3. Зохиогч номоо хэвлүүлснээс хойш 50 жилийн хугацаанд бөө шүтлэгийн ялангуяа, Их Монгол улс, Юаны үеийн хэрэглэгдэхүүн ихээр хуримтлуулсан байна.

4. 2009 онд Олон улсын монгол судлалын 50 жилийн ой тохиох жил таарсан тул тус зохиолоо (эхний хэвлэл нь монголч эрдэмтэдийн анхдугаар хуралд зориулагдсан) мөн энэ түүхт ойн өмнө дахин хэвлүүлэх боломж гарсан зэрэг олон бодит шалтгаануудыг дурдаж болно.

Ч.Далай 2 дахь хэвлэлд тавигдах эдгээр шаардлагуудыг хангасан зохиолынхоо төлөвлөгөөг мөхөс надад (С.Өлзийбаяр) танилцуулахдаа миний зүгээс хүлээж авах боломжгүй хамтын зохиогч болох тухай санал тавьж байсан юм. Харамсалтай нь түүний лагшин илт дордож, хэвтрийн дэглэм сахих болсон учраас энэхүү алдарт зохиолыг дахин хэвлүүлэх нэр хүндтэй ажил надад завшаанаар тохиосон юм. Зохиогчийн зөвлөгөөний дагуу 1. хятад хэлнээс хөрвүүлсэн учраас зарим цөөн өгүүлбэрийн найруулга засах, 2. шашингүйн үзлийн үүднээс бөө мөргөлийг феодал ангийн үзэл суртлын зэвсэг хэмээн тайлбарласан үзэл баримтлалаас татгалзаж монголчуудын оюуны үнэт өв болох талаас нь харуулахыг оролдох, 3. “Монголын Юань улс”, “Их Монгол” улс зэрэг нэг сэдэвт зохиолуудад бичсэн бөөгийн

холбогдолтой зүйлүүдийг холбогдох гарчгийн дор байрлуулах зэрэг зарим нэг техник голдуу засвар хийгээд зохиолын эхийг гэрт нь очиж танилцуулсан юм. Буурал академич энэ зохиолынхоо өмнөх үгийг надад хэлж бичүүлэхдээ “номын нөхөд, судлаач залуустаа монгол судлалын салбарт өнө мөнхөд үнэлэгдэх бүтээл арвинтай байхын ерөөл өргөхийн хамт эх түүх, хэл, соёлоо үеийн үедээ нандигнан өвлүүлж, цэвэр тунгалаг хадгалах сэтгэлийн тэнхээ, оюуны цартай өргөн уншигч түмэндээ энэхүү бэсрэг бүтээлээ барьж байна” гэсэн утгатай үгээр төгсгөхийг хүссэн юм. Түүний энэ хүсэлт нь хойч үеийн судлаач, өргөн олон түмэндээ хандсан захиас байжээ гэдгийг тухайн үед хэрхэн ухаарах билээ.

Арваад хоногийн дараа мөхөс би дахин бараалхаж номын хэвлэлийн зардлын талаар Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааг далимдуулан нэр дэвшигч нутгийнх нь хүүгээр санхүүжүүлэх боломжийн талаар саналаа хэлэхэд тэрээр эрс татгалзсан хариу өгсөн юм. Түүнийг амьсгал хураахаас хэдхэн хоногийн өмнө тус зохиолыг “Монголын бөө мөргөлийн түүх” нэртэйгээр хэвлүүлсэн билээ. Ингэж тус зохиол нь Ч.Далайн анхны бүтээл болсон бол 50 жилийн дараа дахин хэвлэгдэхдээ нэрт түүхч, академич, шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн буурал эрдэмтний бүтээлийн жаргах наран болж мөнхрөх тавилантай ажээ. Түүний эхлүүлсэн бөө шүтлэгийн салбар судалгааг олон арван шавь нар нь үеэс үед нэр төртэй үргэлжлүүлсээр байх нь дамжиггүй бизээ.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Ся Янь, Чжан Чжи-сян нар БНМАУ-ын Соёлын яамны сайд Сосорбарамтай уулзсан тухай // ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив 1956 он, хавтас №39
2. Х.Буянбат. Монголын бөөгийн шашны учир. Хөх хот, 1985, Ёнсог. Монгол шашин суртахууны тойм. Хөх хот, 1992, Д.Мансан. Монгол бөө мөргөл. Хөх хот, 1990
3. Ч.Далай. Монголын бөө мөргөлийн түүх (нэмэн засварласан 2 дахь хэвлэл) УБ., 2009. т.23